



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/68/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртгэл



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	111
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.19 № 103

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Татварын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520024



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга, С.Бямбарагчаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 07-ноос 2020 оны 02 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 66 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зөв зохион байгуулж, татвар төлөгчдөд татварын үйлчилгээг хүнд сурталгүй, хөнгөн шуурхай, ил тод нээлттэй үйлчилж, шударга үйл ажиллагаатай хууль хэрэгжүүлэгч байгууллага болох"-д оршино.

Татварын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Сургалт сурталчилгаа явуулах, хяналт тавих
- Улс, аймаг, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Эмералд” программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 23 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 603,924.1 мянган төгрөгөөс тооцон 12,078.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 16,204.9 мянган төгрөгөөр тооцсон нь тайлант онд санхүүжилт өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,542.8 мянган төгрөгөөр буюу 4,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	27.2	27.2	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	9,060.4	9,517.0	456.6
Үндсэн хөрөнгө	570,314.1	628,464.7	58,150.6
Хуримтлагдсан элэгдэл	-131,958.7	-143,567.6	-11,608.9
Нийт хөрөнгө	447,443.1	494,441.3	46,998.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	447,443.1	494,441.3	46,998.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	447,443.1	494,441.3	46,998.2

Авлага дансны үлдэгдэл өссөн /буурсан асуудал байхгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь үнэт цаасны үлдэгдэл, малын нас дэвшилтээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд аж ахуйн материал 5,837.7 мянган төгрөг, мал амьтад 1,650.0 мянган төгрөг, 1,110,9 мянган төгрөгийн үнэт цаас байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Татварын ерөнхий газар болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.



Хөрөнгө оруулалтаар барилга байгууламж 9,000.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 42,206.4 мянган төгрөг, тавилга эд хогшил 31,277.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данснаас акталсан 24.333,5 мянган төгрөгийн хөрөнгөөр буурсан байна.

Биет бус хөрөнгөд өссөн буурсан асуудал байхгүй байна.

Өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 494,441.3 мянган төгрөг болж 46,998.2 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 739,872.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 739,872.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 739,846.4 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас 67,969.1 мянган нэмэлт санхүүжилтийг шилжүүлсэн байна.

Үүнээс хөрөнгө оруулалтад 37,967.6 мянга төгрөг, болзолт уралдаанд 15,000.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 13,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 23 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 22 эрсдэл тодорхойлж нийт 22 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 5,084.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,621.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 675.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 716.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,070.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 2,462.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,392.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Шатахууны зарцуулалтын тайлангийн анхан шатны баримт жолоочийн замын хуудаст бичигдсэн км-ыг тооцон үзэхэд 716,897 төгрөгөөр илүү,



спидометрийн заалт бичигдээгүй тооцоо бодоогүй, замын хуудсан дахь тээврийн хэрэгсэл зөрүүтэй зөрчлүүд байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3.-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ, хэмжилт, үнэн зөв батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Нярвын тайлангаарх эхний болон эцсийн үлдэгдэл 285,165 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Үйлчлүүлэгч иргэдэд татварын тайлангийн маягт борлуулж зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа явуулсан байна. Хураан авсан 390,000 төгрөгийн орлогыг бүртгэл тайланд тусгаагүй, зарцуулалтын тайлан байхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн оршин байх, үнэлгээ, хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн 1,070.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймаг дахь Татварын хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.



2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймаг дахь Татварын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Ерөнхий журналаас тээвэр шатахууныг түүвэрлэн авч тодруулга тайлан анхан шатны тайлантай тулган үзэхэд тээвэр шатахууны зардлаас 111,697 төгрөгийн ахмадын санд шилжүүлсэн байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: ЗГ-ын 2017 оны 197 тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулах ажиллах журам"-ыг мөрдөж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэн ажиллана.

2. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн Б/62 дугаар захирамжаар хэлтсийн даргад үр дүнгийн 958,520 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.
- 2.2. Эрсдэл: Төсвийн сахилга хариуцлага алдагдах.
- 2.3. Өгсөн зөвлөмж: ЗГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох" журмын 1.2.1 -д "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох



гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9 087 650,47	9 544 231,30
33	АВЛАГА	27 250,00	27 250,00
335	Бусад авлага	27 250,00	27 250,00
3351	Байгууллагаас авах авлага	27 250,00	27 250,00
35	БАРАА МАТЕРИАЛ	9 060 400,47	9 516 981,30
354	Хангамжийн материал	7 575 400,47	7 866 981,30
35410	Бичиг хэргийн материал	1 461 564,28	1 621 903,80
35420	Аж ахуйн материал	5 980 836,19	5 837 670,00
35430	Сэлбэг хэрэгсэл	133 000,00	133 000,00
35440	Түлш, шатах тослох материал	00,00	274 407,50
35600	Мал амьтад	1 485 000,00	1 650 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	438 355 443,45	476 441 657,09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	438 355 443,45	476 441 657,09
392	Биет хөрөнгө	384 530 443,45	422 616 657,09
39201	Барилга, байгууламж, орон сууц	221 345 593,11	230 345 593,11
39202	Хуримтлагдсан элэгдэл	00,00	-6 493 440,52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100 950 000,00	100 950 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12 451 375,29	-23 334 824,84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	139 145 667,69	157 617 750,76
39206	Хуримтлагдсан элэгдэл	-88 148 929,92	-86 188 613,49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48 571 330,40	79 249 813,40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31 358 363,20	-35 343 510,04
39214	Бусад үндсэн хөрөнгө	6 476 520,66	6 476 520,66
39215	Хуримтлагдсан элэгдэл	00,00	-662 631,95
393	Биет бус хөрөнгө	53 825 000,00	53 825 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	53 825 000,00	53 825 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	447 443 093,92	485 985 888,39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	447 443 093,92	485 985 888,39
51	Засгийн газрын хувь оролцоо	447 443 093,92	485 985 888,39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	351 819 591,65	351 819 591,65
51101	Өмч: - төрийн	351 819 591,65	351 819 591,65
512	Хуримтлагдсан үр дүн	-65 888 860,11	-27 346 065,64
51210	Өмнөх үеийн үр дүн	-153 218 720,44	-66 081 159,09
51220	Тайлант үеийн үр дүн	87 329 860,33	38 735 093,45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	161 512 362,38	161 512 362,38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	447 443 093,92	485 985 888,39



Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	723 570 911,46	857 620 144,75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97 805 161,46	49 780 201,75
120	Нийтлэг татварын бус орлого	97 805 161,46	49 780 201,75
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94 545 350,00	49 780 201,75
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	93 063 400,00	49 780 201,75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	627 247 700,00	807 839 943,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	591 397 700,00	739 872 300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	591 397 700,00	739 872 300,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10 850 000,00	30 000 000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10 850 000,00	30 000 000,00
1330	Төсвийн захирагчдаас	25 000 000,00	37 967 643,00
133003	Хөрөнгийн	25 000 000,00	37 967 643,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	636 241 051,13	818 698 504,17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	636 241 051,13	818 698 504,17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	635 491 051,13	806 944 727,17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	475 826 864,00	575 082 127,00
210101	Үндсэн цалин	416 501 986,00	467 648 759,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20 579 200,00	38 868 000,00
210104	Урамшуулал	38 745 678,00	68 565 368,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53 164 236,00	74 055 424,00
210201	Тэтгэврийн даатгал	35 722 444,00	48 306 875,00
210202	Тэтгэмжийн даатгал	4 375 063,00	6 447 551,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 466 534,00	5 157 840,00
210204	Ажилгүйдлийн даатгал	863 859,00	1 285 924,00
210205	Эрүүл мэндийн даатгал	8 736 336,00	12 857 234,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11 235 900,00	11 204 300,00
210301	Гэрэл, цахилгаан	4 868 869,00	3 270 242,00
210302	Түлш, халаалт	3 452 196,00	4 864 017,00
210303	Цэвэр, бохир ус	2 914 835,00	3 070 041,00
2104	Хангамж, бараа материалын зардал	21 096 118,00	23 264 419,99
210401	Бичиг хэрэг	8 535 912,00	10 950 564,30
210402	Тээвэр, шатахуун	5 560 228,00	3 755 204,50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 960 129,00	3 241 078,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	911 664,00	1 099 785,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 128 185,00	1 522 636,00
210408	Бараа материал акталсны зардал	00,00	2 695 152,19
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5 080 300,00	4 300 000,00
210604	Урсгал засвар	5 080 300,00	4 300 000,00
2107	Томилолт, зочны зардал	4 064 499,00	6 000 000,00
210702	Дотоод албан томилолт	4 064 499,00	6 000 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23 256 803,00	24 946 641,20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17 794 200,00	21 372 172,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360 000,00	360 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 585 000,00	1 659 900,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181 800,00	128 900,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00,00	22 000,00
210807	Газрын төлбөр	00,00	155 500,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3 335 803,00	1 248 169,20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41 766 331,13	88 091 814,98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	780 000,00	1 485 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8 669 359,00	45 188 072,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	32 316 972,13	41 418 742,98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	750 000,00	11 753 777,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	750 000,00	11 727 900,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	750 000,00	9 907 900,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00,00	1 820 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00,00	25 877,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00,00	25 877,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	87 329 860,33	38 921 640,58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00,00	186 547,13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00,00	339 027,13
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00,00	-152 480,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00,00	-186 547,13
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	87 329 860,33	38 735 093,45



Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	613 598 729,00	817 593 092,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1 481 950,00	777 410,00
120	Нийтлэг татварын бус орлого	1 481 950,00	777 410,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1 481 950,00	777 410,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1 481 950,00	777 410,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	612 116 779,00	816 815 682,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	591 397 700,00	739 872 300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	591 397 700,00	739 872 300,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10 850 000,00	67 967 643,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00,00	30 000 000,00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10 850 000,00	37 967 643,00
1330	Төсвийн захирагчдаас	9 869 079,00	8 975 739,00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9 869 079,00	8 975 739,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	613 598 729,00	779 625 449,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	613 598 729,00	779 625 449,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	602 979 150,00	744 215 933,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471 381 300,00	563 188 023,00
210101	Үндсэн цалин	332 387 300,00	374 417 155,00
210102	Нэмэгдэл	72 821 800,00	101 327 500,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20 854 000,00	18 878 000,00
210104	Урамшуулал	45 318 200,00	68 565 368,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57 609 800,00	70 401 700,00
210201	Тэтгэврийн даатгал	38 847 400,00	48 475 100,00
210202	Тэтгэмжийн даатгал	4 690 600,00	5 481 700,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 752 500,00	4 385 300,00
210204	Ажилгүйдлийн даатгал	938 100,00	1 096 300,00
210205	Эрүүл мэндийн даатгал	9 381 200,00	10 963 300,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11 235 900,00	11 213 900,00
210301	Гэрэл, цахилгаан	3 831 364,00	3 300 000,00
210302	Түлш, халаалт	4 335 946,00	4 834 259,00
210303	Цэвэр, бохир ус	3 068 590,00	3 079 641,00
2104	Хангамж, бараа материалын зардал	18 074 500,00	19 788 600,00
210401	Бичиг хэрэг	6 567 682,00	9 907 060,00
210402	Тээвэр, шатахуун	4 338 773,00	4 029 612,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5 040 129,00	3 263 078,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 122 600,00	1 122 600,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 005 316,00	1 466 250,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6 000 000,00	4 300 000,00
210604	Урсгал засвар	6 000 000,00	4 300 000,00
2107	Томилолт, зочны зардал	4 699 400,00	6 000 000,00
210702	Дотоод албан томилолт	4 699 400,00	6 000 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22 528 250,00	25 023 710,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18 920 000,00	21 920 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360 000,00	360 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 585 000,00	1 659 900,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181 800,00	145 900,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00,00	5 000,00
210807	Газрын төлбөр	00,00	155 500,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1 481 450,00	777 410,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11 450 000,00	44 300 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11 450 000,00	44 300 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10 619 579,00	35 409 516,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10 619 079,00	35 383 639,00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9 869 079,00	8 975 739,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	750 000,00	9 907 900,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00,00	16 500 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	500,00	25 877,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	500,00	25 877,00



3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00,00	37 967 643,00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	37 967 643,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00,00	37 967 643,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00,00	37 967 643,00
2200	Дотоод эх үүсвэрээр	00,00	37 967 643,00
223001	Бусад хөрөнгө	00,00	37 967 643,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00,00	-37 967 643,00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	00,00	00,00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	351 819 591,65	161 512 362,38	-65 888 860,11	447 443 093,92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	192 298,98	192 298,98
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	351 819 591,65	161 512 362,38	-65 888 860,11	447 635 392,90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	38 735 093,45	38 735 093,45
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	351 819 591,65	161 512 362,38	-27 346 065,64	485 985 888,39



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	591 397 700,00	602 262 650,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	591 397 700,00	602 262 650,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591 397 700,00	601 512 650,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471 381 300,00	471 381 300,00
210101	Үндсэн цалин	332 387 300,00	332 387 300,00
210102	Нэмэгдэл	72 821 800,00	72 821 800,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20 854 000,00	20 854 000,00
210104	Урамшуулал	45 318 200,00	45 318 200,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57 609 800,00	57 609 800,00
210201	Тэтгэврийн даатгал	38 847 400,00	38 847 400,00
210202	Тэтгэмжийн даатгал	4 690 600,00	4 690 600,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 752 500,00	3 752 500,00
210204	Ажилгүйдлийн даатгал	938 100,00	938 100,00
210205	Эрүүл мэндийн даатгал	9 381 200,00	9 381 200,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11 235 900,00	11 235 900,00
210301	Гэрэл, цахилгаан	3 322 000,00	3 831 364,00
210302	Түлш, халаалт	6 647 200,00	4 335 946,00
210303	Цэвэр, бохир ус	1 266 700,00	3 068 590,00
2104	Хангамж, бараа материалын зардал	17 824 500,00	18 074 500,00
210401	Бичиг хэрэг	4 000 000,00	6 567 682,00
210402	Тээвэр, шатахуун	5 935 900,00	4 338 773,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5 266 000,00	5 040 129,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 122 600,00	1 122 600,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 000 000,00	1 005 316,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6 000 000,00	6 000 000,00
210604	Урсгал засвар	6 000 000,00	6 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	4 699 400,00	4 699 400,00
210702	Дотоод албан томилолт	4 699 400,00	4 699 400,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17 646 800,00	21 061 750,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төл	15 520 000,00	18 920 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360 000,00	360 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 585 000,00	1 585 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181 800,00	181 800,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5000000,00	11450000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5 000 000,00	11 450 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0,00	750000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00,00	750 000,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00,00	750 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	591 397 700,00	591 412 650,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	591 397 700,00	591 397 700,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	591 397 700,00	591 397 700,00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00,00	14 950,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00,00	14 950,00